



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2014.05.27 № А-1/602
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Улсын Их Хурлаас 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 62 дугаар тогтоол болон Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг оны эхний улирлын байдлаар боловсруулж, хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 25 хуудастай.



14 1946

A5-2014.doc

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ
УИХ-ЫН 62 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ
(2014 оны 1 дүгээр улирлын байдлаар)**

2. Эдийн засгийн бодит салбарыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллах


2013 оноос эхлэн инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан үед мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4, 6 дугаар сард, нийт 2.75 нэгж хувиар бууруулж, 2013 оны 6 дугаар сараас хойш 10.5%-д өөрчлөлгүй хадгалан, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжсэн нь ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.7%-д гарч 3 жил дараалан хоёр оронтой тоонд, 2014 оны 1 дүгээр улиралд 7.4%-д гарч 2013 оны эхний улирлаас 0.3 нэгж хувиар өндөр байхад эерэгээр нөлөөлөв. Монголбанк 2012 оны 11 дүгээр сараас эхлэн эдийн засгийн тогтворжуулах бодлого хэрэгжүүлж, мөнгөний нийлүүлэлтийг хувийн хэвшлээр дамжуулан бодит секторт эргэлтийн хөрөнгийн зээл олгох хэлбэрээр нэмэгдүүлсэн нь хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтвортой өндөр түвшинд хадгалагдах, барилга угсралт, тээвэр ба агуулахын салбарын өсөлтийг эрс нэмэгдүүлж, ажлын байрыг хамгаалахад чухал нөлөө үзүүлсээр байна.

Хүснэгт 1: ДНБ-ий бодит өсөлт (%)


Бодит ДНБ	2013 оны I улиралд	2014 оны I улиралд
ДНБ-ий бодит өсөлт (%)	7.1%	7.4%
Хөдөө аж ахуй	20.3%	18.4%
Уул уурхай	4.6%	27.3%
Боловсруулах үйлдвэрлэл	18.5%	-12.9%
Цахилгаан, хий, уур	6.4%	3.0%
Барилга	8.3%	18.0%
Бөөний ба жижиглэн худалдаа	-0.9%	-12.2%
Тээвэр ба агуулах	-0.5%	15.5%
Мэдээлэл, жолбоо	16.0%	1.9%
Бусад үйлчилгээ	10.4%	10.8%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	8.2%	-4.2%

Эх сурвалжууд: УСХ

Зураг 1: Улирлын ДНБ-ий бодит өсөлт (%)



Зураг 2: Гадаад, дотоод цэвэр актив (тэрбум төгрөг)



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 3: ГЦА, ДЦА-ын жилийн өөрчлөлт (%)



2014 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА)-ын хэмжээ өнгөрсөн оны сүүлээс 431 тэрбум төгрөгөөр буюу 46%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 3.4 их наяд төгрөгөөр буюу 87%-иар буураад байна. Гадаад цэвэр активын хэмжээ ийнхүү огцом буурч байгаа нь эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал болон төлбөрийн нийт тэнцэл оны эхнээс төдийлөн сайжрахгүй байгаатай холбоотой юм. Ийнхүү гадаад валютын урсгал сайжрахгүй, төлбөрийн тэнцэл оны эхний улиралд 308 сая

ам.долларын алдагдалтай гарсан нь эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломжийг хязгаарлаж, мөнгөний бодлогын хүүг бууруулах, бодит сектор дахь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Хэдий тийм боловч, Монголбанк эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөх зарим арга хэмжээг Засгийн газартай хамтран тайлант улиралд боловсруулж, хэрэгжүүлэхэд бэлэн болгоод байна. Үүнд:

1. Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас хараат байдлыг бууруулах замаар эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах зорилтын хүрээнд Монголбанкнаас **“Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх, санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх”** бодлогын судалгааг мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг салбарыг хамруулан гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны үр дүнд ноос ноолуур, арьс шир боловсруулах, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар ашигт малтмалын бус экспортын тогтвортой орлогыг бий болгох нь нэн тэргүүний зорилт гэж тодорхойлсон болно.

Энэ хүрээнд Монголбанкнаас ҮХААЯ, СЯ-тай хамтран ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх (НҮДЭН) арга хэмжээний схем, НҮДЭН арга хэмжээг хэрэгжүүлэх журам, Засгийн газрын батлан даалтын гэрээ, Монголбанкнаас банктай байгуулах зээлийн гэрээ, зээлийн эх үүсвэрийг олгох, буцаан төлүүлэх, хяналт тавих механизм, аргачлалыг тус тус боловсруулан баталж, Засгийн газраар холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. Энэхүү арга хэмжээ нь дараах схемээр хэрэгжинэ:

- ҮХААЯ-тай гэрээ байгуулсан үндэсний үйлдвэрүүд өөрийн эх үүсвэрээр, эсхүл өөрийн хөрөнгийг барьцаалж авсан зээлээр түүхий эдийн эхлэлийн нөөцийг ХАА-н биржээр дамжуулан бүрдүүлэх,
- Монголбанк зээлийн эх үүсвэрийг үйлдвэрийн худалдан авсан, сертификатаар баталгаажсан түүхий ноолуурын агуулахын нөөцөд тулгуурлан банкинд хэсэгчлэн олгоно. Энэ нь зөвхөн түүхий ноолуур худалдан авч, боловсруулан экспортлоход зориулагдах бөгөөд нийт санхүүжилтийн 70% байх,
- Үйлдвэрүүд түүхий эдийн баталгаажсан агуулах дахь нөөцийн үлдэгдлийг барьцаалж, дараагийн түүхий эд бэлтгэлд зориулан банкуудаас эргэлтийн хөрөнгийн зээл авах,
- Үйлдвэрүүд түүхий эдийг боловсруулж, самнасан ноолуур үйлдвэрлэн экспортлох, банкнаас авсан зээлээ 2014 онд багтаан бүрэн төлж дуусгах,
- Хэрэв зээлийн эргэн төлөлт нь гэрээнд заасан тодорхой хугацаанаас хоцрох тохиолдолд зээлийн хүү нь өсөн нэмэгдэх зохицуулалт үйлчлэх,
- Арга хэмжээнд зориулан Монголбанкнаас гаргах эх үүсвэрт учирч болзошгүй гадаад зах зээлийн эрсдэлд Засгийн газрыг төлөөлж Сангийн яам батлан даалт гаргах.

Арга хэмжээний үр дүнд самнасан ноолуурын үйлдвэрлэл, экспортын орлого нэмэгдэж, 2014 оны төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлөх, үйлдвэрүүдийн тогтвортой үйл ажиллагаа хангагдан ажлын байрууд хадгалагдах богино хугацааны үр дүн хүлээгдэнэ. Харин дунд хугацаанд хөдлөх хөрөнгийг барьцаалж, ноолуурын түүхий эдийн агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн бий болох, үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа бэхжих, үйлдвэрлэлээ өргөтгөх, ашигт малтмалын бус салбарын экспорт өсөн нэмэгдэх үр дүн хүлээгдэхээр байна.

2. Монголбанкнаас ЭЗХЯ, УУЯ-тай хамтран алт олборлолт, тушаалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх, эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилгоор *“Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга*

хэмжээ”-ний төслийг боловсрууллаа. УИХ-аас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монголбанк болон банкуудад тушаагдах алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5% болгон бууруулсан нь дотоодын алт олборлолт, тушаалтыг нэмэгдүүлэх эерэг өөрчлөлт болсон. Гэхдээ дэлхийн зах зээл дэх алтны үнэ буурсан, Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оноос эхлэн огцом багассан, төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн улмаас дотоодын аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн эх үүсвэрийн дутагдал бий болсон зэрэг нь алт олборлолтод сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд алтны салбарын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, алтны үнийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах замаар 2014 онд алт олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Монголбанк, УУЯ, ЭЗХЯ хамтран “Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ”-ний төслийг боловсруулж, түүнийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв. Энэхүү арга хэмжээний үр дүнд Монголбанкинд тушаагдах алтны хэмжээ 2014 онд 10-11 тоннд хүрэх, улмаар гадаад валютын улсын нөөц 400-450 сая ам.доллараар нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

3. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг үргэлжлүүлэн бууруулах, эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилгоор “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд тайлант улиралд 34 тэрбум төгрөгийн зээлийг банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Үүний 80%-ийг Монголбанкны, 20%-ийг банкууд өөрийн эх үүсвэрээр олгосон бөгөөд цаашид нийт олгох зээлд Монголбанкны эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ буурах, банкуудын өөрийн эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэх зохицуулалт 2014 оноос эхлэн үйлчилж байна. Дунд хугацаанд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлснээр Монголбанк хөтөлбөрөөс үе шаттай гарах юм. Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн хэмжээ 2014 оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үеэс 31%-иар буурчээ.

3.1. Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр 2014-2016 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Санхүүгийн салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх бодлогын баримт бичгийг олон улсын санхүүгийн байгууллагуудын техник туслалцаатайгаар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагатай хамтран боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанкнаас Дэлхийн банкинд санал тавьж, хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллуулах саналыг СЯ, ЭЗХЯ, СЗХ-нд тус тус хүргүүлэв. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох чиглэлээр Монголын Ипотекийн корпорацитай хамтран ажиллаж байна.

Монголбанкнаас санхүүгийн зах зээлийн зохистой бүтэц, чөлөөт өрсөлдөөний орчин, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх талаар судалгаа хийж байгаа бөгөөд уг асуудалд Монголбанкнаас баримтлах бодлого, зарчмын байр суурь, оролцооны хэм хэмжээг тодорхойлох зорилгоор өндөр хөгжилтэй орны Төв банкны чиг үүрэг, туршлагыг судалж байна. Үүний зэрэгцээ даатгал болон хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих замаар санхүүгийн зах зээлийн олон тулгуурт бүтцийг бий болгох, улмаар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, тэдгээрийг алслагдсан бүс нутагт хүргэх чиглэлийг энэхүү бодлогын баримт бичигт тусгахаар төлөвлөж байгаа болно.

Монголбанкнаас СЗХ-той хамтран кастодиан үйлчилгээг манай орны санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэхүү үйлчилгээ нь хөрөнгийн зах зээлийн арилжааны дараах үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчийн үнэт цаасыг түүний зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах боломжийг хязгаарлах давуу талтай юм. Үүнээс гадна дотоодын кастодиан үйлчилгээ үзүүлэгч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн кастодиан үйлчилгээ үзүүлэгчийн дэд-кастодиан болох замаар Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бололцоо бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, гадны хөрөнгө оруулагч нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг нэр хүнд бүхий кастодиан банкаар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын кастодиан банктай холбогдож, хөрөнгө оруулалт хийх бололцоотой болно.

Монголбанк санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх хүрээнд банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар, журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, хүү тооцох аргачлалыг шалгах ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэлээ. Уг шалгалтын үр дүнд Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, зээлийн бодит өртөг зардал, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах, санхүүгийн зах зээлд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд банкуудын хүү бодох аргачлалыг боловсронгуй болгож мөрдүүлэх, хадгаламж, зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулж, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Монголбанк “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинээр боловсруулан, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтад үндэслэн баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү журамд зээлийн бодит өртөг, хадгаламжийн бодит үйлчилж буй хүүг тооцож мэдээлэх, зээл, хадгаламж, үнэт цаасны өдрийн хүү тооцох суурь хоногийг стандартчилах, нэмэгдүүлсэн хүү тооцох аргачлал, шимтгэл, хураамжийн нөхцөл, мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тодорхой тусгасан болно. Журмыг хэрэгжүүлэх хүрээнд банкуудын хүү, шимтгэл, хураамжийн 2014 оны эхний 3 сарын мэдээллийг Монголбанкнаас нэгтгэн, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

Энэхүү журмыг баталж хэрэгжүүлснээр зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангуулах, хүүг нэгдсэн аргачлалаар тооцдог болох, хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл, хураамжийг олон нийтэд ил тод байлгах, харилцагчдыг оновчтой, зөв сонголт хийх боломжоор хангах, банкуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсний үндсэн дээр цаашид зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох юм.

3.2. Эдийн засгийн бодит салбарын идэвхжилийг дэмжих зорилгоор “Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанк зээлийн хүү өндөр түвшинд тогтоход нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн таатай орчныг бий болгох замаар зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх зорилго бүхий хөтөлбөрийг анх Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (хуучин

нэрээр)-ны даргын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 677/229/188/142 тоот хамтарсан тушаалаар баталж, 2013 оныг дуустал хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд тус хөтөлбөрийн хүрээнд инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг үндсэн 4 чиглэлээр тодорхой зорилтууд тавьж хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- **Зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор Монголбанкнаас бодлогын дараах арга хэмжээнүүдийг авсан.**

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны 1 дүгээр сарын 25, 4 дүгээр сарын 8, 6 дугаар сарын 25-ны өдрүүдэд тус тус хуралдаж мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих үүднээс мөнгөний бодлогын хүүг 13.25%-иас шат дараалан бууруулан 10.5%-д хүргэсэн. Мөнгөний бодлогын зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 11-ний хуралдаанаар макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг хангах хүрээнд мөнгөний бодлогын хүүг 10.5%-д хэвээр үлдээх, түүнчлэн олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрүүдийг тус тус гаргасан. Эдгээр нь нэг талаас тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих макро бодлогыг тууштай үргэлжлүүлж, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих, нөгөө талаас эдийн засаг дахь урт хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэрүүд байв.

Түүнчлэн, дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүгийн коридорыг 2013 оны 2 дугаар сарын 27-нд шинээр нэвтрүүлснээр банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, хүүний хэлбэлзэл буурах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах суурь нөхцөл бүрдэхийн зэрэгцээ Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурч, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлж байна.

- **Хэрэглээний үнийн индекст голлох нөлөөтэй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлж, оновчтой хуваарилан, нийлүүлэлтийг жигд хангаж, үнийн хэлбэлзлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлсэн.**

Монголбанк эрэлтийн инфляцийг бага байлгахын зэрэгцээ Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулах чиглэлд ажиллаж, нийлүүлэлтийн гаралтай инфляци үүсэх хүчин зүйлсийн үндсэн шалтгааныг арилгах, мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг хэрэглээний суурь барааны нийлүүлэлтийг сайжруулах замаар үнийн өсөлтийг нь тогтворжуулах, дунд хугацаанд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд нийлүүлэлтийн гаралтай инфляци мэдэгдэхүйц буурч, хөтөлбөрт хамрагдаж буй бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нь өмнөх онуудтай харьцуулахад үлэмж буураад байна.

- **Банкуудын зээлийн журам, түүний хэрэгжилтэд үзлэг шалтгалт хийх, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах болон зээлдэгчдэд учрах хүү, шимтгэлийн дарамтыг багасгах чиглэлээр холбогдох арга хэмжээ авсан.**

Монголбанкнаас ажлын хэсэг байгуулж, 2012 онд банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн байдал, хүү тооцох аргачлал зэргийг бүх банкууд дээр очиж шалгалт хийсэн. Шалгалтын дүгнэлтэд үндэслэн “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” болон “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү болон үнэт цаасны өгөөж, хямдруулалтын хувь хэмжээг бодох ерөнхий аргачлал”-ыг тус тус боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар баталсан.

- **Зээлийн мэдээллийн санг өргөтгөх ажлын хүрээнд төрийн эрх бүхий байгууллагатай холбогдох, тэдгээрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, түүнд банк, санхүүгийн байгууллагууд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн.**

Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр нийт 13 банк, 112 банк бус санхүүгийн байгууллага, 34 хадгаламж зээлийн хоршоотой мэдээлэл солилцож байна.

- **Мөнгөний захын хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, жишиг хүү болон өгөөжийн муруйг бий болгох үүднээс Засгийн газрын богино, дунд, урт хугацаат дотоодын үнэт цаасны арилжааг тогтмолжуулсан.**

Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, арилжааг тогтмол хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/А-161 дугаар тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг баталсан.

Мөнгөний захын хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, жишиг хүү болон өгөөжийн муруйг бий болгох үүднээс Засгийн газар Монголбанкны арилжааны дэд бүтэц (платформ)-ийг ашиглан 12, 28, 52 долоо хоногийн дунд хугацаатай, 3, 5, 10 жилийн урт хугацаатай үнэт цаасыг банк хоорондын зах дээр арилжаалж байна. 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар богино хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 586 тэрбум, дунд болон урт хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 1445.8 тэрбум төгрөг байна.

- **Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн.**

"Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дууссантай холбогдуулан Монголбанк, Засгийн газар, СЗХ-наас хамтран "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай" хуулийг УИХ-аар 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр шинээр батлуулсан.

- **Зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн даатгал, баталгаа, батлан даалтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчин бүрдсэн.**

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль”-ийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Энэхүү хууль батлагдсанаас хойш зээлийн батлан даалтын сан байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, жигдрүүлэх ажлууд хийгдсэн.

- **Хувь хүн болон компанийн зээлийн түүхийн мэдээллийн сангийн найдвартай байдал, үйл ажиллагааг сайжруулж, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.**

Зээлийн мэдээллийн чанар агууламжийг сайжруулах, зээлийн мэдээллийн лавлагааг түгээх сувгийн хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн “Зээлийн мэдээллийн тухай хууль” батлагдсан. Хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээллийг хадгалах, боловсруулах зэрэгт нууцлал, аюулгүй байдлын талаарх тодорхой шаардлагууд тавигдаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдалд тавих хяналт, хариуцлагыг тодорхой болгосон. Түүнчлэн, тус хуулийн хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн байгууллага эрхлэх боломжтой болж байгаатай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-197 дугаар тушаалаар “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг баталсан.

- **“Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2013-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийн талаар**

Монголбанкнаас “Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2013-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийг 2013 оны эхний хагаст холбогдох байгууллага, газруудаас санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж, түүнийг батлах тухай хамтарсан тушаал болон хөтөлбөрийн шинэчилсэн хувилбарыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдаар батлуулсан. Харин уг баримт бичгийг Эдийн засгийн хөгжлийн сайдаар батлуулахаар Монголбанкны 2013 оны 9 дүгээр сарын 23-ны А-16/1226 тоот албан бичгээр хүргүүлснээс хойш өнөөг хүртэлх хугацаанд хөтөлбөр ЭЗХЯ-аар батлагдаагүй буюу албажаагүй байна. Монголбанкны зүгээс хөтөлбөрийг батлуулах ажлыг хурдавчлуулах утга бүхий 2013 оны 10 дугаар сарын 16-ны А-3/1354, 2013 оны 12 дугаар сарын 10-ны А-1/1569, 2014 оны 03 дугаар сарын 05-ны А-1/259, 2014 оны 04 дүгээр сарын 04-ний А-3/412, 2014 оны 04 дүгээр сарын 29-ний А-3/495 тоот буюу нийт 5 удаагийн албан бичгийг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн боловч одоогоор хариу ирүүлээгүй байна.

Шинэчилсэн хөтөлбөр ийнхүү ЭЗХЯ-наас шалтгаалан батлагдаагүй байгаа хэдий ч, Монголбанкны хувьд 2014 онд төлөвлөсөн ажлуудаа хийж байна. Тухайлбал, санхүүгийн зах зээлд оролцогчдын суурь мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулан, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12-р сарын 13-ны өдрийн тушаалаар баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдүүлж эхлээд байна. Уг журмын дагуу банкуудын зээл, хадгаламжийн хүү, шимтгэл хураамжийн мэдээллийг банк тус бүрээр харьцуулсан байдлаар сар бүр, бүтээгдэхүүний төрөл тус бүрээр Монголбанкны цахим хуудаст нийтэлдэг боллоо. Ингэснээр банкны харилцагчдад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг ил тод байлгах, банкуудын зээлийн хүүг харьцуулах боломжийг харилцагчдад

олгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкуудын хүүгийн өрсөлдөөнийг дэмжих замаар зээлийн хүү буурах орчныг сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2014 оны 3 дугаар сард банкуудын тэтгэврийн зээлийн нөхцөл, хүү тооцож буй аргачлалыг шалгаж, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй зарим банкинд улсын байцаагчийн акт тогтоох, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч байна. Мөн энэхүү журам батлагдсантай уялдан банкуудын ажилтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчидтэй 2014 оны 2 дугаар сард зээлийн бодит өртгийн талаар ярилцлага, уулзалт, сургалтуудыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгөв.

Монголбанк хадгаламжийн даатгалын системийг бүрэн нэвтрүүлэх хүрээнд 2013 онд УИХ-аар батлуулсан “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн хэрэгжилтийг Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран хангаж, тус системийг нэвтрүүлэх ажлыг хийж байгаа болно.

Банкуудын төгрөгийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 3 дугаар сарын байдлаар 19.7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн хэдий ч, Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол 17.8% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна. Харин гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 3 дугаар сарын байдлаар 12.7% болж өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ.

3.3. Бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжиж ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанкнаас банкуудаар дамжуулан бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилт хийх тохиолдолд энэ нь банкууд, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд, бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн асуудалд Төв банкны зүгээс баримтлах бодлого, зарчим, оролцооны хэм хэмжээний талаар олон улсын жишиг, практикт үндэслэсэн судалгааг хийж эхлээд байгаагийн зэрэгцээ энэ чиглэлд Санхүүгийн зохицуулах хороо болон ББСБ-ын холбоотой хамтран ажиллаж байна.

Мөн тогтвортой болон оролцоотой санхүүжилт, байгаль орчин, ногоон бизнесийн санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд Монголын банкуудын холбоо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай хамтран тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн ажлын хэсгийг байгуулах бөгөөд уг ажлын хэсэг нь “*Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөө хамтарсан тунхаг бичиг*”-ийг боловсруулах юм.

Монголбанк бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, байнгын, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2012 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг мөн дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 5 дэд хөтөлбөрийн хүрээнд банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 230 орчим аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээл олгожээ. Мөн банкууд орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зориулж 97 компанид Монголбанкны эх үүсвэрээр зээл олгосон байна.

Монголбанкнаас банкуудаар дамжуулан олгох төслийн зээлүүдийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгон ажиллаж байна. Тухайлбал, ХБНГУ-ын

Сэргээн босголт, хөгжлийн банк (КФВ)-ны санхүүжилттэй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хүрээнд Монголбанк 2014 оны 1 дүгээр улиралд 42 ЖДҮ эрхэлдэг аж ахуйн нэгжид 7.0 сая еврогийн зээл олгоод байна.


Мөн, Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хүрээнд тайлант улирлын эцсийн байдлаар нийт 7 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд 1.08 тэрбум төгрөгийн зээлийг оролцогч банкуудаар дамжуулан олгов. Уг төслийн хүрээнд 2013 оны эцсийн байдлаар нийт 283 ажлын байр шинээр бий болсон юм.

3.4. Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанкнаас валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор оны эхнээс нийт 33 удаа валютын дуудлага худалдааг зохион байгуулж, шаардлагатай зохицуулалтыг тухай бүр хийсэн. Үүний үр дүнд гадаад зах зээлээс дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаа, эдийн засаг дахь зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлэн, санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэв. Мөн шаардлагатай үед юанийн спот захад оролцох нөхцөлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ төгрөг-ам.долларын болон төгрөг-юанийн своп, форвард хэлцлүүдийг банкуудтай тогтмол хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалахын зэрэгцээ санхүүгийн салбарыг бүхэлд нь системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой байна. 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.5 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 95 сая юанийн своп хэлцлийг банкуудтай байгууллаа.

Үүний үр дүнд оны эхнээс 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуусталх хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.97%-иар чангарч, 1.66%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.23% байна. Мөн хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 87%-д нь 0.4% дотор, үлдсэн 13%-д нь хамгийн ихдээ 1.97%-иар хэлбэлзжээ. Гэсэн ч ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.23% байгаа нь 2013 оны мөн үеэс 0.12 нэгж хувиар их, 2012 оны мөн үетэй ижил түвшинд байна.

Зураг 4: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (интервалаар)



Эх сурвалж: Монголбанк

Валютын захад тогтворгүй байдал үүссэн буюу онцгой нөхцөлд Монголбанкнаас авах арга хэмжээний төлөвлөгөө (contingency plan)-г боловсруулж байна. Уг төлөвлөгөөг 2014 оны 2 дугаар улиралд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулахаар төлөвлөж байна.

Монголбанкнаас гадаад валютын ханшийн эрсдэлээс үүдэлтэй зээлийн эрсдэлийг бууруулах макро болон микро зохистой бодлогын хувилбаруудыг бусад улс орны шилдэг туршлагад үндэслэн судалж байна. Энэ хүрээнд төгрөгийн орлоготой этгээдэд гадаад валютын зээл олгохгүй байхыг банкуудад зөвлөмж хэлбэрээр хүргүүлж, гадаад валютын зээл авч байгаа этгээдэд ямар валютаар орлого олдгоос нь үл хамаарч ханшийн эрсдэлийг бууруулах санхүүгийн үүсмэл хэрэгсэл заавал ашиглахыг шаардах зохицуулалтыг холбогдох журам, зааврын хүрээнд хийж байна. Түүнчлэн, гадаад валютын зээл олгоход банкуудад тавих зохистой харьцааны шалгуурыг чангатгах замаар төлбөрийн чадварын болон зээлийн эрсдэлийг бууруулах боломжуудыг судалж байна.

3.5. Валютын захад банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчийг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны тогтолцоог бий болгох (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголбанкт хамтран валют арилжааны тогтолцоог бий болгох чиглэлээр хамтран ажиллаж эхлээд байна. Энэ хүрээнд банк, банк бус санхүүгийн байгууллага болон санхүүгийн зах зээлийн бусад оролцогчид гадаад валютын spot болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн арилжааг дуудлага худалдааны зарчмаар хийх буюу “Валют арилжааны платформ”-ыг бий болгох, түүгээр дамжуулж арилжаа хийх боломжуудыг судалж байна. Гадаад валютын дуудлага худалдааг банк бус санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдын хувьд нэвтрүүлэхэд нь Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн байгууллагын холбоонд арга зүйн зөвлөмж өгөх чиглэлээр Монголбанк ажиллах юм.

3.6. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь макро эдийн засгийн төлөв байдал, эдийн засагт учирч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, бодлогын харилцан уялдааг хангах тухай болон цаг үеийн шинжтэй бусад асуудлаар зөвлөлдөж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдааныг 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Монголбанкн дээр зохион байгуулсан бөгөөд тус хуралдаанаар: (i) 2014 оны эхний 2 сарын байдлаарх макро эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшид нөлөөлсөн хүчин зүйлс, (ii) АНУ-ын иргэн, хуулийн этгээдийн “Гадаад дахь дансдын хөрөнгийг татварт хамруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар АНУ-ын зүгээс тавьсан хүсэлтийн тухай, (iii) Урт хугацааны даатгалтай холбоотой эрх зүйн орчны зарим асуудлууд, (iv) Монголбанкнаас боловсруулдаг бусад санхүүгийн байгууллагын тоймын хамрах хүрээг сайжруулах санал зэрэг асуудлыг авч хэлэлцсэн болно. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн.

Тухайлбал, оны эхнээс гадаад худалдаа тэнцвэржиж байгаа хэдий ч, санхүүгийн дансны урсгал, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц сайжраагүй, экспортод гаргасан нүүрсний орлогын зарим хэсэг нь орж ирээгүй зэргээс шалтгаалж төлбөрийн тэнцэл дэх дарамт арилахгүй байна. Ийм орчинд улсын төсвөөр дамжуулж буюу түүнээс гадуур төсөвтэй адилтгах төгрөгийн зарцуулалтыг Хөгжлийн банк, Төрийн банкнаас гэнэт хийх нь валютын захад сөргөөр нөлөөлөх, улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг богино хугацаанд сулруулахад нөлөөлж байгааг тогтоов. Энэ үндсэн дээр СЯ, ЭЗХЯ, Хөгжлийн банкнаас ирээдүйд хийх төгрөгийн зарцуулалтын мэдээг 7 хоног тутамд Монголбанкинд хүргүүлж, урьдчилан мэдээлж байх замаар макро бодлогын харилцан уялдааг хангаж байхаар тогтсон.

СТБЗ нь улирал бүр хуралдах хуваарьтай байгаа бөгөөд шаардлагатай гэж үзсэн тухай бүр ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах боломжтой байна.

Монголбанк дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба (СТБЗАА) нь тайлант улиралд “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн 2 дахь дугаарыг нэгтгэн боловсруулж хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж олон нийтийн хүртээл болгов. Санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлон, эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн макро зохистой бодлогын арга хэмжээг судалж, бодлогын санал боловсруулах ажлын хүрээнд хагас жил тутам гардаг “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-д макро зохистой бодлогын арга хэрэгслүүдтэй холбоотой асуудлуудыг тусгаж оруулсан. Түүнчлэн, хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн макро зохистой бодлогын арга, хэрэгслүүдийн талаар судалгаа хийж байна. 2014 оны эхний хагас жилд багтаан Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 3 дахь дугаарыг бэлтгэн гаргана.

СТБЗАА-наас “Макро эдийн засаг, санхүүгийн салбарын улирлын тойм”-ыг боловсруулж, улирал бүрийн дараа улирлын 2 дахь сард багтаан цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлэхээр ажиллаж байна.

Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо нь өөрсдийн хариуцсан чиглэлээр санхүүгийн салбар, гадаад сектор, макро эдийн засгийн талаарх тайлан мэдээлэл, статистик мэдээ, судалгаа шинжилгээг боловсруулж, өдөр, сар, улирлын давтамжтайгаар, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол түгээж байгаа болно.

5.1. Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээг тогтмол хийж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, УИХ-ын ЭЗБХ болон СТБЗ-д танилцуулж байх

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Fitch агентлаг 2013 оны 12 дугаар сард, Standard and Poors' (S&P) агентлаг 2013 оны 4 дүгээр сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлвийг “тогтвортой” гэсэн үзүүлэлтээс “сөрөг” үзүүлэлттэй болгосон байна. Тайлант улиралд зэрэглэл тогтоогч байгууллагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулаагүй байгаа хэдий ч, 2014 оны 4 дүгээр сард S&P агентлаг улсын зээлжих зэрэглэлийг өөрчлөх магадлалтай байгаа юм.

Монголбанкнаас “Монгол Улсын зээлжих зэрэглэлд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ”-г гүйцэтгэж байна. Энэхүү шинжилгээний тайланд зээлжих зэрэглэлийн өөрчлөгдсөн байдал, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагын зэрэглэлийг үнэлэх аргачлал, зэрэглэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ, дүгнэлт болон цаашид зэрэглэлийг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг тус тус оруулах юм.

Шинжилгээний тайланг 2014 оны 2 дугаар улиралд багтаан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд тус тус хүргүүлэх болно.

5.2. Монголбанкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хараат бус гишүүд бүхий мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох чиглэлээр Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

Монголбанк Төв банкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын сайн туршлагаудыг Монголбанкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх үндэс суурийг бүрдүүлэх, хараат бус гишүүд бүхий Мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох зорилгоор дэлхийн улс орнуудын төв банкны тухай хуулиудыг судалж дуусаад байна. Түүнчлэн, ОУВС-гийн мэргэжилтнүүд, “Төсөөлөл бодлогын шинжилгээний систем (FPAS)” төслийн зөвлөхүүдтэй уулзалт хийж, улс орнуудын төв банкны хараат бус байдлыг хэрхэн бэхжүүлэх, Мөнгөний бодлогын зөвлөлийн нийтлэг зарчмуудыг илүү сайн хангах чиглэлээр зөвлөлдөв. Дээрх зөвлөхүүд Мөнгөний бодлогын зөвлөлийн олон улсын сайн туршлагад хамаарах 5 зарчмыг² хуульдаа тусгахыг зөвлөмж болгосон. Эдгээр судалгаа, зөвлөмжид үндэслэн Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж эхлээд байна.

5.3. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах механизм, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, санхүүгийн салбарт үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах бодлогын уялдааг хангах үр дүнтэй институци болгох чиглэлээр Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын хэсэг томилон ажиллуулж байгаа бөгөөд тус ажлын хэсэг нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалыг боловсруулж эхлээд байна.

Хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулахад дэмжлэг болгох үүднээс Монголбанкин дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанаас тайлант хугацаанд “*Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэгч институцийн загвар: Олон улсын түвшинд харьцуулсан судалгаа*”-г гүйцэтгэлээ. Энэхүү суурь судалгаа нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий институцид өөрийн орны онцлогт тохирсон эрх зүйн оновчтой зохицуулалтыг бий болгоход чухал алхам болов.

6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийг Олон улсын байгууллага /ФАТФ/-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулах, холбогдох журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах (Засгийн газар, Монголбанк)

2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Эдгээр хуулийн төслийг боловсруулахад Монголбанк, Санхүүгийн мэдээллийн

² (i) Зөвлөлийн гишүүдийг 5-аас доошгүй жилээр томилж ажиллуулах, (ii) Засгийн газрын гишүүнийг тус зөвлөлд оруулахгүй байх, (iii) Гишүүнийг нэр дэвшүүлэх, батламжлах субъектүүд нь өөр өөр байх буюу “2 алхамт” системээр зохицуулагддаг байх, (iv) Гишүүдийн цалин нь гишүүнээр ажиллах хугацаанд буурдаггүй байх, (v) Гишүүдийг чөлөөлөх үйл явцыг нарийвчлан тусгах, зөвхөн ноцтой тохиолдолд гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлдөг байх гэх мэт.

алба голлож оролцсон бөгөөд уг хуулиуд батлагдсанаар Монгол Улсаас ФАТФ-тай хийхээр тохирсон ажлууд бүрэн хийгдсэнд тооцогдсон болно. Улмаар 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Францын Парис хотноо болж өнгөрсөн ФАТФ-ын 22 дахь удаагийн чуулга уулзалтаар Монгол Улсын зэрэглэлийг ахиулж, ФАТФ-ын “хар саарал” жагсаалтад байсныг “саарал” болгож өөрчиллөө. 2014 оны 5 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд ФАТФ-аас томилогдсон Бүс нутгийн хяналтын бүлгийн гишүүд Монгол Улсад хүрэлцэн ирж, ФАТФ-тай тохирсон ажлуудын хэрэгжилтийг газар дээр нь шалгаж баталгаажуулсны дараа 2014 оны 6 дугаар сард ОХУ-ын Москва хотод болох ФАТФ-ын 23 дахь удаагийн чуулга уулзалтаар ФАТФ Монгол Улсын зэрэглэлийг дахин ахиулж, “саарал” жагсаалтаас гаргаж, ФАТФ-ын хяналтын цахим хуудаснаас Монгол Улсын нэрийг бүрмөсөн арилгах ажил хүлээгдэж байна.


2014 оны 5 дугаар сарын 12-16-нд болох Бүс нутгийн хяналтын уулзалтыг Монголбанкин дээр хийх бөгөөд уулзалтын бэлтгэл ажлуудыг хангаж эхлээд байна. Холбогдох бүх яам, агентлагуудад энэ талаар албан тоот явуулж, мэдээллийг хүргүүлээд байна. Тус уулзалтад яам, агентлагуудаас оролцох албан тушаалтнуудын нэрсийг авч бүртгэсэн бөгөөд Бүс нутгийн хяналтын бүлэгт урьдчилсан тайланг боловсруулж хүргүүлээд байна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ
 (2014 оны 1 дүгээр улирлын байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:


1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 онд 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу инфляцийг хязгаарлах, мөнгө, төсвийн бодлогын харилцан уялдааг хангах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана. Эдгээрийн үр дүнд дунд болон урт хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ

Зураг 5: УБ хотын сарын ба жилийн инфляци



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 6: Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жилийн инфляци 2014 оны 3-р сарын байдлаар улсын хэмжээнд **12.4%**, Улаанбаатар хотын хэмжээнд **11.9%** байлаа. Харин өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 12.6% байжээ. Энэ оны 3-р сард хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ улсын хэмжээнд 0.8%-иар, Улаанбаатар хотын хэмжээнд 0.5%-иар нэмэгдсэн байна.


2014 оны 3-р сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (11.9%-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн 1.09, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 2.19, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.93, шатахуун -0.02, бусад бараа, үйлчилгээ (зураг 6-д улаан өнгөөр тэмдэглэсэн) 6.73 нэгж хувийг тус тус бүрдүүлжээ. Бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувийг өмнөх 2-р сартай харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн, шатахууны инфляцид эзлэх хувь хэмжээ

харгалзан 0.3, 0.03 нэгж хувиар өссөн бол махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, бусад бараа, бүтээгдэхүүний инфляцид эзлэх хувь хэмжээ харгалзан 0.31, 0.01, 0.11 нэгж хувиар тус тус буурсан байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслээр инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийг зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо руу шилжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд өргөн хэрэглээний суурь бараа,

бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт саарав. Тухайлбал, хүнсний бараа, үйлчилгээний инфляци 2012 онд 19.9% байсан бол 2013 онд 14%, 2014 оны 3-р сард 10% болж буурсан бол 2012 онд 44% байсан махны үнийн өсөлт 2013 онд 10.5%, 2014 оны 3-р сард 7.4% болж буураад байна.


Зураг 7: Монголбанк төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралын нөлөөллийг бага, дунд орлоготой иргэдийн хувьд зөөлрүүлэв



Эх сурвалж: Монголбанк

2014 оны 3-р сарын байдлаар Улаанбаатар хотын инфляци 11.9% гарсан нь инфляцийн зорилтот түвшнээс 3.9 нэгж хувиар өндөр байна. Энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан болон төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ өссөнөөс шалтгаалав. Тухайлбал, төрийн өмчийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр 33.2%-иар өссөн нь 1.0 нэгж хувийн, орон сууцны халаалтын үнэ 27.1%-иар өссөн нь 0.2 нэгж хувийн, цахилгааны үнэ дунджаар 11.4%-иар өссөн нь 0.2 нэгж хувийн, авто замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ дунджаар 17.7%-иар өссөн нь 0.5 нэгж хувийн буюу нийтдээ 1.9 нэгж хувийн инфляцийг бий болгожээ. 2014 оны 4-р сарын 10-ны байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2013 оны 7-р сарын дунд үетэй харьцуулахад 18.5%-иар сулраад байгаа нь “Бусад” ангиллын бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувь тухайн үеэс 2.4 нэгж хувиар өсөхөд нөлөөллөө.

Зураг 8: Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан барааны инфляци болон бусад барааны инфляци (2008-2014 оны 3-р сар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Өөрөөр хэлбэл хэрэглээний үнийн индексийн өсөлтөд нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци эрс буурсан байгаа бол валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан инфляци өссөн байна. Гэхдээ валютын ханш тогтворжиход түүний инфляци дахь нөлөөлөл нь буурах болно.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 2-р сарын 7-11-ний өдрүүдэд хуралдаж, Бодлогын хүүг 10.5 хувьд хэвээр үлдээх, олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан. Бодлогын энэхүү арга хэмжээ нь нэг талаас эдийн засгийн бодит секторын идэвхжлийг дэмжих, нөгөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 32%-иар, гадаад цэвэр актив “Чингис” бондын хөрөнгийг оруулахгүй тооцвол 1.2³ тэрбум ам.доллараар тус тус буурсан, төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байгаа орчинд гадаад валютын урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой байв.

Монголбанк Засгийн газартай хамтран ажиллах хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдэлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой юм. Түүнчлэн, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах, дотоодын аж ахуйн нэгжид учирч байгаа эрсдэл, ачааллыг бууруулах, санхүү, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн УИХ-ын тогтоол, шийдвэр гаргуулахаар Засгийн газартай хамтран ажиллаж, тодорхой чиглэлүүдээр санал боловсруулж хүргүүлэн, Ажлын хэсэгт орж ажиллалаа.

Мөнгөний болон төсвийн бодлогын харилцан уялдааг сайжруулах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 129/133 дугаар хамтарсан тушаалаар “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг баталсан. Уг журамд Сангийн яам төсвийн гол үзүүлэлтүүдийн төсөөлөл болон Төрийн сангийн нэгдсэн данс (ТСНД)-ны орлого, зарлагын гүйлгээний таамаглал, бодит гүйцэтгэлийг 7 хоног, сар, улирлын давтамжтайгаар Монголбанкинд хүргүүлж байхаар заасан. Гэвч Сангийн яамнаас ирүүлж буй мэдээллийн чанар хангалттай бус, давтамж цөөн байснаас мэдээллийг мөнгөний бодлогын төсөөлөл, бодлогын шинжилгээнд ашиглахад хүндрэлтэй байв. Тухайлбал, ТСНД-ны мөнгөн хөрөнгийн урсгалын ажлын 5 хоногийн таамаглалыг 7 хоног бүр ирүүлээгүй, зарлагын бодит гүйцэтгэлийг 2014 оны эхний 3 сард огт ирүүлээгүй, түүнчлэн дээрх мэдээллийг валютын төрлөөр, томоохон бүлгээр ангилан авах тухай журмын заалтыг Сангийн яам мөрдөн ажиллахгүй байна. Иймд, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 3-р сарын 28-ны өдрийн хуралдаанаар Сангийн яам болон Монголбанкны хооронд байгуулсан мэдээлэл солилцох журмын хэрэгжилтийг Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ийг хамруулан сайжруулах, Эдийн засгийн хөгжлийн яам, МУХБ нь холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж, нэгдсэн мэдээллийг Сангийн яамнаас Монголбанкинд хүргүүлж байхаар шийдвэрлэв. Энэ нь мөнгөний бодлогын шийдвэрт улсын төсөв, МУХБ-ны мэдээллийг цаг алдалгүй авч ашиглах, мэдээллийн хоцрогдол, тодорхой бус байдлыг бууруулах боломжийг олгохоор байна.

³ 2014 оны 2-р сарын байдлаар

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчим баримтална

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтож байх зарчмыг үргэлжлүүлэн баримталж байгаа бөгөөд валютын ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай тохиолдолд тухай бүр оролцож байна.

Сүүлийн хоёр улиралд гадаад зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт, дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ сэргэх хандлага ажиглагдахгүй байгаа, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч байгаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц сэргээгүй зэрэг нь Монгол Улсын төлбөрийн тэнцлийн дарамтыг арилгахгүй байна. Мөнгөжөөгүй алт, боловсруулаагүй нефть, зэсийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний экспорт 2014 он гарсаар нэмэгдсэн хэдий ч, чулуун нүүрсний экспортын орлого тодорхой хугацааны дараа орж ирэхээр байгаагаас шалтгаалан валютын зах дээр богино хугацааны эрэлт нийлүүлэлтийн зөрүү үүсэх эрсдэл байсаар байна. Түүнчлэн, 2014 он гарсаар жижиг, дунд хэмжээний төслүүдэд оруулж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа хэдий ч, Оюутолгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалт дууссантай холбоотойгоор эхний 3 сарын байдлаар Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үеэс 38%-иар буураад байна. Ийм орчинд Монголбанк валютын захад тогтмол оролцоотой ажиллаж, спот болон своп хэлцлийн арилжаагаар захад валют нийлүүлж байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр оны эхнээс 7%-иар суларсан байна. 2013 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 19%-иар суларсан болон оны эхнээс ханш сулрах хандлага үргэлжилж байгаа нь гадаад худалдаа, төлбөрийн урсгал дансанд шаардлагатай тохиргоог хийж байна.

Зураг 9: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ба урсгал данс



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш ийнхүү эдийн засгийн нөхцөл байдалтай нийцтэйгээр уян хатан тогтож байгаа нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулж, хувийн хэвшилд ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч, төгрөгийн тогтвортой байдал буюу үнийн тогтвортой байдлыг хангах Монголбанкны үндсэн зорилттой нийцтэй бөгөөд дунд болон урт хугацаанд экспортыг урамшуулах, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, үр ашиггүй, тэвчиж болох импортыг бууруулах, гадаад худалдааны алдагдал болон төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах, эдийн засгийн өрсөлдөх чадвар болон урт

хугацааны дархлааг сайжруулах боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал 2014 оны 3 дугаар сарын байдлаар валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл 37.7 сая ам.долларын ашигтай гарлаа. Үүнд төгрөгийн ханш суларснаар валютын төлбөртэй импортын дүн 17%-иар буурсан нь голлон нөлөөлжээ.

1.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ

Урт хугацаат своп хэлцэл байгуулах: Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, валютын зээлийн өсөлтийг бууруулах, ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгох хүрээнд банкууд урт хугацаат гадаад эх үүсвэрээр Монголбанктай своп хэлцэл хийж, ханшийн эрсдэлээ бууруулах боломжтой болов. Ингэснээр банкуудын валютын ханшийн эрсдэлээс ААНБ, иргэд бүрэн хамгаалагдаж байгаа юм. Урт хугацаат своп хэлцэл нь 1 ба түүнээс дээш жилийн хугацаатай байгуулагдах шинэ санхүүгийн үүсмэл хэрэгслийн бүтээгдэхүүн юм. Монголбанк 2014 оны 4 дугаар сарын 28-ний өдрийн байдлаар нийт 152 сая ам.доллартай тэнцэх хэмжээний урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулаад байна.

Валютын дуудлага худалдаагаар санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг идэвхтэй ашиглах: Монголбанкнаас санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг дэмжих зорилгоор банкуудтай своп хэлцлийг тогтмол хийж байна. Монголбанк 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.5 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 95 сая юанийн своп хэлцлийг банкуудтай байгуулжээ.

Төгрөгийн орлоготой зээлдэгчдийг валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг бий болгох: Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцооны хүрээнд төгрөгийн орлоготой, валютын зээлтэй этгээдийн хувьд ханшийн эрсдэлээс хамгаалах бүтээгдэхүүн ашиглах нөхцөл боломжийг судалж байна. Ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй этгээд нь i) инфляцийг импортолж үнийн түвшинг нэмэгдүүлэх, ii) ханшийн хэлбэлзлээс шалтгаалж их хэмжээний алдагдалд орох эрсдэлтэй бөгөөд уг алдагдал нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг. Иймд ханшийн эрсдэлийг бууруулахад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг өргөнөөр ашиглах шаардлага зайлшгүй тулгарч байгаа юм. Монголбанкнаас төгрөгийн орлоготой зээлдэгчдийг валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг бий болгохоор холбогдох судалгааг гүйцэтгэж эхлээд байна.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд форвард хэлцэл байгуулах: Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шатахуун импортлогч компаниудтай форвард хэлцлийг байгуулж байна. 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 281 сая ам.долларын форвард хэлцлийн төлбөр тооцоог хийсэн бөгөөд 301 сая ам.долларын форвард хэлцэл идэвхтэй байна. Энэ нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэлийг бууруулж, дотоодын зах зээлд шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байхад эерэгээр нөлөөлөв.

Валютын зээлийг тогтворжуулах макро зохистой арга хэрэгслийг судлах: Гадаад валютын зээлийн өсөлтийг сааруулах, системийн шинжтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглах хэрэгцээ, шаардлага тулгарч байгаа бөгөөд Монголбанк энэ чиглэлээр судалгаа хийж байна.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1. Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ

Монголбанкнаас 2014 оны 1 дүгээр улиралд нийт 4 банкинд иж бүрэн, 1 банкинд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж, илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Шалгалтын мөрөөр гарсан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж байна.

Мөн Банкны тухай хууль, *Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан* “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

2014 оны 1 дүгээр улирлын байдлаар банкны салбарын I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.2%, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.6% байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 3.2 ба 4.6 нэгж хувиар тус тус өндөр байна. Үүнээс гадна банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байна. Тайлант улирлын эцэст тус харьцаа 41.9%-д хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 16.9 нэгж хувиар өндөр байв. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа ийнхүү өндөр байхад банкуудын хөрвөх чадвар сайтай, богино хугацаат хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлт эерэгээр нөлөөлсөн.

Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. Тайлант улирлын эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт хамгийн өндөр нэгж валютын хувьд -11.6 хувь, нийт валютын хувьд 18.4 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг цаашид хэрхэн хангах, банкны үйл ажиллагаанаас болон нийт банкны систем, эдийн засгийн нөхцөл байдлаас үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор Монголбанкнаас банкуудаар мэдрэмтгий байдлын шинжилгээг хийлгэж хэвшүүлэхээр ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлох үүднээс 2014 оны 1 дүгээр улиралд зээлийн эрсдэл, том зээлдэгч, ханшийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэсэн 4 чиглэлд мэдрэмтгий байдлын шинжилгээг хийж, гарсан үр дүнг цаашид баримтлах бодлогод тусгахаар ажиллаж байна.

Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг боловсронгуй болгох зорилгоор тэдгээрийн хоорондын уялдаа, хэрэгжилтэд учирсан хүндрэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд өөрчилж шинэчлэх ажлын хүрээнд Монголын банкуудын холбоо, банкууд болон бусад холбогдох байгууллагаас ирүүлж буй банкны үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын саналыг нэгтгэж, судалгаа хийж эхлээд байна.

2.2. Олон улсад мөрддөг зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагаатай уялдуулан, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна

Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай байгаа тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхийг эрсдэл өндөртэй байгаа үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улмаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг бууруулах зохицуулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гарын авлага боловсруулахаар тус асуудлаар мэргэшсэн олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмын төслийг боловсруулж байна.

Мөн “Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”-ийн төслийг боловсруулж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасан болно. Ингэснээр нийт банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, хяналт шалгалтын олон улсад мөрдөгдөх стандартад нийцсэн хяналт, зохицуулалтын аргачлалыг ашиглах боломж бүрдэнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн төсөл болон түүний хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг Компанийн засаглалын хөгжлийн төв болон Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдтэй хамтран олон улсын стандартын үндсэн зарчмуудтай нийцүүлэн боловсрууллаа. “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг үнэлэх загварын талаар холбогдох байгууллагуудтай хамтран хэд хэдэн сургалт зохион байгуулж, журмын төслийн талаар танилцуулга хийсэн болно. Журмын төслийг 2014 оны 2 дугаар улиралд багтаан батлуулахаар төлөвлөж байна.

2.3. Банкны эрсдэл, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн болон зээл, хүүгийн зардлыг нэмэгдүүлж байгаа бусад хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах эрх зүйн орчныг шинэчилнэ

Банкны салбараас алслагдсан, санхүүгийн мэдээлэл багатай, ялангуяа хөдөө, орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг үр ашигтай болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-236 тоот тушаалаар баталсан. Энэхүү журмын дагуу банкуудын хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийгэд шаардлагатай мэдээллийг тогтмол түгээж байна. Уг журмын хэрэгжилт нь нийгэд ижил, тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах ажлуудыг шалгах, хөдөө, орон нутагт олгогдож байгаа зээлийн нөхцөлийг газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор орон нутгийн банкуудад хэсэгчилсэн шалгалтыг 2014 оны 5, 6 дугаар саруудад хийхээр төлөвлөсөн болно.

Банкуудын үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх, хэрэв төр, захиргааны байгууллагаас шалтгаалж банкны үйл ажиллагааны зардал нэмэгдэж байгаа бол тэр чиглэлд холбогдох арга хэмжээг авах, банкуудад зөвлөмж өгөх чиглэлээр Монголбанк

ажиллаж байна. Түүнчлэн, банкуудын үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн талаар Монголын банкуудын холбооноос санал авах, банкнаас өөрөөс нь шалтгаалж бий болдог зардал болон иргэд, харилцагчид дээр ирдэг зардлын бүтцэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэх арга хэмжээ авахаар ажиллаж байгаа болно.

Монголбанк Хөдлөх хөрөнгө, эрхийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль, Эрхийн улсын бүртгэлийн багц хуулийн төсөлд УИХ, Хууль Зүйн Яамтай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулан, Монголын банкуудын холбоо, банкууд болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж саналыг нэгтгэсэн. Хуулийн төслүүдийг Засгийн газраас УИХ-д өргөн барих ажил хүлээгдэж байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2014-2016 онд эрчимжүүлнэ

- **“Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөрийн систем, картын нэгдсэн сүлжээ болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах:**

Монголбанк “Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөрийн систем болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Үнэт цаасны цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-өөр 2014 оны 1 дүгээр улиралд нийт 314 тэрбум төгрөгийн дүнтэй 6.2 сая ширхэг картын гүйлгээ, 155 тэрбум төгрөгийн дүнтэй 1.3 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ, “Банксүлжээ” системээр 12.7 их наяд төгрөгийн дүнтэй 248.2 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ тус тус амжилттай боловсруулагджээ.

Банк хоорондын картын сүлжээний оролцогчдын найдвартай, тасралтгүй ажиллагаа тайлант улиралд дараах гүйцэтгэлтэй⁴ байлаа:

- ХААН банк - 99.5%
- ХХБ - 99.94%
- Голомт банк - 99.65%
- Төрийн банк - 99.78%
- Үндэсний цахим гүйлгээний төв - 99.98%

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээг 24/7 онлайн горимд шилжүүлэх ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014.01.28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 12 оролцогчийн банк хоорондын бага дүнтэй гүйлгээ дамжуулах үйл ажиллагаанд 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрөөс 2 дугаар сарын 18-ны өдрүүдэд газар дээрх хяналт шалгалтыг хийлээ. Үүгээр нийт оролцогчид “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-ын 4.1.3, 4.1.4, “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-ний 1.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй, төлбөр тооцоог гар ажиллагаатай хийсэн, шалгалт хийсэн 1 өдрийн саатлын дансанд 354.7 сая төгрөгийн 2688 гүйлгээг саатуулсан болохыг шалгаж тогтоов. Мөн дээрх шалгалтын явцад зөвхөн ажлын өдөр 9-17 цагийн хооронд бага дүнтэй гүйлгээг илгээж, хүлээн авдаг гэх буруу ойлголт бүх шатанд байсан, үүний улмаас бага дүнтэй гүйлгээний талаар буруу мэдээлэл гарч байсныг илрүүллээ.

Монголбанкны удирдлагын түвшинд энэхүү шалгалтын тайланг хэлэлцэж, шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг арилгуулах тухай Улсын байцаагчийн мэдэгдлийг албан бичгийн

⁴ 99.5%-иас дээш гүйцэтгэлтэй байвал системийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн гэж үздэг.

хамт бүх оролцогчдод хүргүүлсэн бөгөөд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс бүх банкууд 24/7 онлайн горимд ажиллахаар боллоо. Банк хоорондын гүйлгээ 24/7 онлайн горимд шилжсэнээр шилжүүлэг, банк хоорондын интернет, мобайл зэрэг гүйлгээнүүд онлайннар хийгдэх боломж бүрдэх юм.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц /СЗЗДБ/-д зарчмын дагуу үнэлгээ хийх аргачлал”-аас банкуудын төлбөрийн системд үнэлгээ хийхтэй холбоотой хэсгийг тусад нь боловсруулах, “СЗЗДБ-ийг үнэлэх үнэлгээний аргачлал болон ил тод байдлыг хангах нь” баримт бичгийн орчуулгыг сайжруулах, үүнтэй уялдан заавар боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Тайлант улиралд Капитал банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Эрэл банкинд дотоодын Мастеркарт төлбөрийн картыг хүлээн авах, Төрийн банкинд картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлүүдийг тус тус олгов. Улаанбаатар хотын банкны зөвшөөрлийн хугацаа дууссан тул зөвшөөрлийг сунгаж, нэмэлт зөвшөөрөл олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор батлагдсан “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу Монголбанк, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах сан, банкууд хамтран ажиллаж байсан. Монголбанк орон нутгийн хэлтэс, салбаруудад энэхүү журмыг хүргүүлж, шаардлагатай мэдээллээр хангасны зэрэгцээ иргэд, зарим банкуудаас ирүүлсэн гомдлын мөрөөр шалгалт хийж, маргаантай асуудлыг шийдвэрлэв.

Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 70 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-д заасны дагуу хүүхдийн мөнгө олгох ажил хийгдэж байна. 2014 оны 1 дүгээр улиралд давхардсан тоогоор 2.9 сая хүүхдэд нийт 58.2 тэрбум төгрөг олгосон байна. Мөн тайлант улиралд 55,849 малчны 15.5 тэрбум төгрөгийн ноосны урамшууллыг олгожээ.

Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв, Монгол шуудан ТӨХК, Эрэл банк хамтран зөрчил гаргасан жолоочид ногдуулах торгуулийг бэлэн бусаар төлөх свайп /swipe/ үйлчилгээг нэвтрүүлэхэд төлбөр тооцоог холбогдох хууль, журамтай нийцүүлэх асуудлын хүрээнд Монголбанкнаас уулзалт зохион байгуулсан.

Төлбөрийн картын журмын дагуу, гэнэтийн саатал их байгааг анхааруулсан албан бичгийг холбогдох банкуудад нь хүргүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан болно.

- **“Төлбөр тооцооны системийн шинэчлэл”-ийг 2014-2016 онд эрчимжүүлэх:**

Төлбөр тооцооны системийг шинэчлэх зорилгоор Монголбанкнаас 2014-2016 онд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Монгол Улсын төлбөрийн системийн шинэчлэл” төслийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төслийн зээлийн гэрээнд ЭЗХЯ болон АХБ, төслийн гэрээнд Монголбанк болон АХБ тус тус 2014 оны 2 дугаар сард гарын үсэг зурсан. ЭЗХЯ уг төслийг УИХ-аар батлуулснаар төсөл хэрэгжинэ.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ 24/7 онлайн горимд тогтвортой ажиллахгүй байгаа шалтгааныг тодруулах, энэ дагуу холбогдох арга хэмжээ авах зорилгоор банкуудад шалгалт хийсэн. Шалгалтын мөрөөр Монголбанкнаас банкуудад банк хоорондын гүйлгээг 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн дотор 24/7 онлайн горимд шилжүүлэх мэдэгдлийг хүргүүлж, 24/7 онлайн горимыг шалгах (тестлэх) ажлыг банкуудтай хамтран эхлүүлээд байна. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс 24/7

онлайн горимд шилжсэнээр банк хоорондын шилжүүлэг болон интернет, мобайл зэрэг гүйлгээ онлайнд шилжих боломж бүрдэнэ.

Дотоодын банкуудын e-commerce буюу картын интернет гүйлгээг ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулах туршилтыг банк хооронд амжилттай хийж, уг гүйлгээг ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулан гүйцэтгэх техникийн боломжийг бүрдүүллээ. Банкуудтай шимтгэлийн нөхцөлүүдийг тохирох, холбогдох журам, гэрээнд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

2012 оны 12 дугаар сараас эхлэн төлбөрийн картын нэгдсэн сүлжээг ашиглан UPI /Union Pay International/, 2014 оны 1 дүгээр сараас JCB /Japanese Credit Bureau/-с гаргасан олон улсын картыг хүлээн авах боломжтой болсон. Ингэснээр эдгээр картыг ашигладаг гадаадын иргэн, жуулчид Монгол Улсад дотоодын картаар үйлчилдэг худалдааны байгууллага, АТМ төхөөрөмжийг ашиглан гүйлгээ хийх боломжоор хангагдсан болно.

- **Төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах:**

Монголбанк Монгол Улсын төлбөрийн системийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор техник туслалцаа авах албан хүсэлтийг Дэлхийн банкинд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Энэхүү техник туслалцаагаар Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжих үүднээс хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төлбөрийн системийн тухай тусгайлсан хуультай болох, урт хугацаанд баримтлан ажиллах төлбөрийн системийн стратегийн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх юм.

Төлбөрийн системтэй холбоотой эрх зүйн дараах баримт бичигт шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан, шинэчлэн батлуулж, системийн нийт оролцогчдод мөрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого
- Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам
- Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого

Картын нэгдсэн сүлжээний хамтран ажиллах гэрээний хугацаа дууссантай холбогдуулан гэрээ болон хавсралтуудад холбогдох өөрчлөлтийг оруулж, “Банк хоорондын картын төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын гэрээ” болгон шинэчлэн боловсруулан, шууд оролцогч дөрвөн банктай гэрээ байгуулав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл батлах тухай” А-250 тоот тушаалаар банк хоорондын бага дүнтэй нэгж гүйлгээний шимтгэл 200 төгрөг байсныг 20 төгрөгөөр бууруулж, 180 төгрөг болголоо. Ингэснээр 2014 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1.3 сая ширхэг банк хоорондын бага дүнтэй гүйлгээ боловсруулж, шинэ шимтгэлээр тооцсоноор банкуудад нийт 25.7 сая төгрөгийн хэмнэлт бий болсон нь нэг талаас банкны төлбөр тооцооны системийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөгөө талаас иргэдийн төлөх шимтгэлийн хэмжээг багасгах боломжийг бүрдүүлэх эхлэл болсон. Цаашид банкинд төлөх харилцагчийн шимтгэлийн хэмжээг бууруулах зорилгоор Монголбанкны зүгээс банк хоорондын цахим худалдан авалтын төлбөр тооцоо, хөдөлгөөнт банкны төлбөр тооцоо зэрэг шинэ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Монголбанк Үндэсний цахим гүйлгээний төвийн хувьчлалын бодлогыг тодорхойлж, энэ онд багтаан олон нийтэд ил тод болгоно.

3.2. Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран эхлүүлнэ

Монголбанкнаас эрх бүхий бусад байгууллагатай санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, мэдээлэл солилцох “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах, хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкуудын холбоотой хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллуулах саналыг эдгээр байгууллагад хүргүүлсэн. Уг ажлын хэсгээс Дэлхийн банктай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах, энэ хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах журам”-ын хэрэгжилтэд Монголбанк тогтмол хяналт тавьж, газар дээрх шалгалтыг тухай бүр хийхийн сацуу журмын хэрэгжилтийн талаарх судалгааг хийж эхлэв.

Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр “Санхүү, банкны нэр томъёоны гарын авлага”-ыг боловсруулж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд Төв банк болон арилжааны банкны үйл ажиллагаа, эрсдэл, санхүүгийн зах зээлийн талаар олон нийтэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

3.3. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслийн ил тод, нээлттэй байдлыг хангах, гаргасан шийдвэрийг олон нийт, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх замаар бодлогын үр нөлөөг сайжруулна

Монголбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлого боловсруулах үйл ажиллагаанд хараат бус төлөөллийг оролцуулах, мөнгөний бодлогын шийдвэрийг оновчтой гаргах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-160 тоот тушаалаар Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийг байгуулж, “Мөнгөний бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг шинээр батлан, уг журамд зөвлөлийн шийдвэр гаргах үйл явц, гарсан шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэр зэрэг зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тусгасан билээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар МБЗ-ийн бүрэлдэхүүнд хараат бус 2 гишүүнийг шинээр томилж ажиллуулах болсон. Одоогоор МБЗ нь 14 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Монголбанкнаас 7 гишүүн, төрийн болон хувийн байгууллага, их сургуулийн багш, судлаачдыг төлөөлсөн хараат бус 7 гишүүн ажиллаж байна. Тус зөвлөл нь мөнгөний бодлогын саналыг батлагдсан журмын дагуу 2-3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэр гаргадаг ба шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гарсан шийдвэрийн үндэслэлийг нь тайлбарлан, хуралдааны тэмдэглэлийг цахим хуудаст байршуулж байна.

МБЗ-өөс тайлант улиралд бодлогын дараах шийдвэрийг гаргасан:

- 2014 оны 2-р сарын 7-11-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 10.5 хувьд хэвээр үлдээх, Олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх.

Олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэл, үйл ажиллагаа, ил тод байдал, бодлогын харилцан уялдаа, макро эдийн засаг, санхүүгийн суурь ойлголт зэрэг өргөн хүрээтэй асуудлаар олон нийт болон хэвлэл, мэдээллийн ажилтнуудад зориулсан цуврал сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, хэрэгжүүлж буй бодлоготой холбоотой бүхий л эрх зүйн баримт бичиг, журам, заавар, судалгааны ажил, тайлан, мэдээлэл, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүнийг Монголбанкны цахим хуудаст байршуулан нийтийн хүртээл болгов. Түүнчлэн эдгээр арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг мөн хамрууллаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

- Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гарсантай холбоотойгоор хэвлэлийн хурлыг 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж 40 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд шуурхай мэдээллээ. Түүнчлэн хэвлэлийн хурлын протокол болон мөнгөний бодлогын мэдэгдлийг англи хэлнээ хөрвүүлж Монголбанкны цахим хуудаст байршуулав.
- МБЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэвлэлийн хурал болсноос хойш 14 хоногийн дотор мөнгөний бодлогын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн товчлолыг гарган Монголбанкны цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлэв.
- Монголбанкны цахим хуудсаар дамжуулан цаг үеийн болон графикт 250 гаруй мэдээ, мэдээллийг нийтэд мэдээлэв. Түүнчлэн, Монголбанкны статистикийн сарын бюллетень, мэдээллийг УИХ, Засгийн газар, банкууд, харилцагч байгууллагуудын цахим хаягаар тухай бүр хүргүүлж байна.
- Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа бодлого, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон цаг үеийн асуудлаар давхардсан тоогоор хэвлэлд 300 гаруй удаа ярилцлага, тодруулга, мэдээлэл өгөв.
- Монголын банкуудын холбоо, Монголбанк хамтран банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд иргэдийн эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах зорилгоор банкуудтай хамтран “Global Money Week 2014” олон улсын арга хэмжээг Монгол Улсад “Хүүхэд бүр санхүүч” уриан дор 2014 оны 3 дугаар сарын 10-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ хүрээнд Монголбанкнаас СЭЗДС, Сант, Шинэ Монгол сургуулийн 400 гаруй оюутан, сурагчдыг Монголбанкинд зочлуулж, макро эдийн засаг, мөнгөний бодлогын талаар цуврал лекцүүд уншлаа.
- Олон нийтийг Монголбанкны үйл ажиллагаатай танилцуулах экскурсыг тогтмол зохион байгуулж байна. СЭЗДС-ийн 350 оюутан, ХААИС-ийн 550 оюутан Монголбанкны үйл ажиллагаатай танилцав.
- “Монголбанкны үйл ажиллагаа, мөнгөний бодлого” сэдвээр лекц уншиж, мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд, СУИС-ийн дэргэдэх РТДС-ийн 300 оюутанд Монголбанкны бодлого, үйл ажиллагааны талаар лекц уншив.